



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
РАШААНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 02 өдөр

Дугаар A/53

Рашаант сум

Сургуулийн орчинд зарим хүнсний
бүтээгдэхүүнийг худалдаалахыг
хориглосон тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Эрүүл Мэндийн сайдын А/370 тоот тушаал, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сургуулийн орчинд үйл ажиллагаа явуулж буй худалдаа үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж, хүнсний дэлгүүрүүд Монгол улсын Эрүүл мэндийн сайдын 2021 оны "Жагсаалт батлах тухай" А/370 тоот тушаалаар баталсан жагсаалтад буй хориглосон хүнсний бүтээгдэхүүнийг хүүхдэд худалдаалахыг хориглосугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сумын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Амаржаргал), Нийгмийн бодлогын мэргэжилтэн (А. Лхагвасүрэн) Хэсгийн цагдаа (Б.Наранбаатар) нарт тус тус даалгасугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг Даргын Тамгын газрын дарга (Т.Отгонцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.АЛТАНГЭРЭЛ